



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
СОЁЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
САЛБАР ЗӨВЛӨЛ**

14190 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Денверийн гудамж, Соёлын яамны байр  
Утас: 26 56 26, Факс: (976-51) 26 56 26  
И-мэйл: info@moc.gov.mn, Веб сайт: www.moc.gov.mn

2022.09.27 № 21

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА ТАНАА**

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрыг байгуулж, Соёлын сайдын 2022 оны А/04 дүгээр тушаалаар тус газрын зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталсан.

Энэ хүрээнд аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 39 дүгээр тогтоол, Соёлын сайдын 2022 оны А/16 дугаар тушаалаар батлан хүргүүлсэн.

Харин төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг жишиг хэлбэрээр боловсруулан Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2022 оны 553 дугаар “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор батлах зөвшөөрлийг олгосныг үүгээр хүргүүлж байна.

Албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн баталж, мөрдлөг болгон ажиллахыг танд зөвлөө.  
Хавсралт 59 хуудастай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНЦЭЦЭГ

220000000003

СТС2259 6594204

71



**МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

2022.09.14 № 03/1825  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
СОЁЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Д.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

**Тогтоол хүргүүлэх тухай**

Аймгуудын Соёл, урлагийн газрын төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг жишиг хэлбэрээр нэгтгэн боловсруулж, зөвшөөрөл авахаар танай салбар зөвлөлийн 2022 оны 10 дугаар албан бичгээр ирүүлснийг тус зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 553 дүгээр тогтоолыг хүргүүлж байна.

Холбогдох байгууллагуудад хүргүүлэх, баталж мөрдүүлэх ажлыг нэгдсэн арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг зөвлөө.

Хавсралт ... хуудастай.

ГИШҮҮН



С.ЦЭДЭНДАМБА

22003928



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 553

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Засгийн газрын “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 2021 оны 377 дугаар тогтоол, Соёлын сайдын “Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтэц, дүрэм батлах тухай” 2022 оны А/04 дүгээр тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Аймгийн Соёл, урлагийн газрын Соёл, урлагийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Захиргаа, удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Хяналт-шинжилгээ, статистик мэдээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг аймгийн Соёл, урлагийн газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

2.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Соёл, урлагийн газрын дарга нарт даалгасугай.

3.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулж, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлийн дарга нарт даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

22001185